

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн “Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2025/004/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuu@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5-8
3. Аудитын илрүүлэлт	13
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОО	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.14 № 397
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хэрлэн тохижилт үйлчилгээ" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Хэрлэн тохижилт үйлчилгээ" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

"Хэрлэн тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын захирал нь Хэрлэн сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнүүлээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

011022178

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12 сарын 31-ний өдөр
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнгэй адилтгах хөрөнгө	18,000.00	2,380,978.00
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.6	Бараа материал	200,000.00	200,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	218,000.00	2,580,978.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	666,950,317.02	1,402,523,422.00
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	666,950,317.02	1,402,523,422.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	667,168,317.02	1,405,104,400.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	-
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч : а) Орон нутгийн өмч	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	28,525,998.16	28,525,998.16
2.3.9	Хуримтлагдсан ашиг	638,642,318.86	1,376,578,401.84
2.3.11	Эздийн өмчийн дүн	667,168,317.02	1,405,104,400.00
2.4	ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН	667,168,317.02	1,405,104,400.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12 сарын 31- ний өдөр
1	Борлуулалтын орлого /цэвэр/	1,628,981,644.07	2,314,812,340.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	1,628,981,644.07	2,314,812,340.00
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	961,813,327.05	1,576,876,257.02
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/	-	-
17	Бусад ашиг /алдагдал/	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	667,168,317.02	737,936,082.98

Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	667,168,317.02	737,936,082.98
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	667,168,317.02	737,936,082.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12 сарын 31-ний өдөр
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	825,513,242.54	1,307,308,000.00
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	-	0.00
	Бусад мөнгөн орлого	825,513,242.54	1,307,308,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	503,122,447.64	1,304,945,022.00
	Ажиллагчдад төлсөн	440,711,241.00	741,078,821.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	62,411,206.64	93,963,065.48
	Бараа материал худалдан авахад төлсөн	-	23,873,510.00
	Ашиглалтын зардалд төлсөн	-	7,993,841.52
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	-	426,907,530.00
	Даатгалын төлбөрт төлсөн	-	6,268,880.00
	Бусад мөнгөн зарлага	-	4,859,374.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	322,390,794.90	2,362,978.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	322,390,794.90	2,362,978.00
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,000.00	18,000.00
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,492,904.92	2,380,978.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	-	-	-	28,525,998.16	638,642,318.86	667,168,317.02
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
3	Залруулсан үлдэгдэл						-

**Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	737,936,082.98	737,936,082.98
5	Бусад дэлгэрэнгүй орлого						-
6	Өмчид гарсан өөрчлөлт						-
7	Зарласан ногдол ашиг						-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
9	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	-	-	-	28,525,998.16	1,376,578,401.84	1,405,104,400.00

2.4 Зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,300,000,000.00	1,304,945,022.00
3	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,000,000.00	1,304,945,022.00
4	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,300,000,000.00	1,304,445,022.00
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,428,715.00	741,078,821.00
6	Үндсэн цалин	732,428,715.00	741,078,821.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,903,685.00	93,963,065.48
12	Тэтгэврийн даатгал	62,081,471.00	55,239,801.48
13	Тэтгэмжийн даатгал	7,303,702.00	6,498,800.00
14	ҮОМШӨ-ний даатгал	20,450,367.00	18,196,643.00
15	Ажилгүйдлийн даатгал	1,460,740.00	1,299,763.00
16	Эрүүл мэндийн даатгал	14,607,405.00	12,728,058.00
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,511,100.00	7,993,841.52
18	Гэрэл, цахилгаан	4,571,100.00	3,663,123.52
19	Түлш, халаалт	5,940,000.00	2,791,140.00
20	Цэвэр, бохир ус		1,539,578.00
22	Хангамж, бараа материалын зардал	381,900,000.00	387,010,434.00
23	Бичиг хэрэг	900,000.00	1,562,300.00
24	Тээвэр, шатахуун	381,000,000.00	383,196,680.00
25	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,264,574.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		986,880.00
30	Нормативт зардал	8,500,000.00	12,036,890.00
32	Хоол, хүнс		8,278,890.00
33	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,500,000.00	3,758,000.00
34	Эд хогшил, урсгал засварын зардал	56,400,000.00	53,667,890.00
35	Багаж, техник, хэрэгсэл		5,100,000.00
37	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,400,000.00	4,857,040.00
38	Урсгал засвар	40,000,000.00	43,710,850.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,356,500.00	6,268,880.00
45	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	588,000.00	588,000.00
46	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	1,740,673.00
47	Тээврийн хэрэгслийн татвар	817,500.00	1,243,507.00
48	Тээврийн хэрэгслийн оношлогоо	451,000.00	1,159,000.00

Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

49	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,500,000.00
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		37,700.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,425,200.00
54	Бараа үйлчилгээний бусад зардал		2,425,200.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	500,000.00
70	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000.00
78	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		500,000.00
94	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,300,000,000.00	1,307,308,000.00
95	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
100	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,300,000,000.00	1,300,000,000.00
101	Орон нутгийн төсвөөс	1,300,000,000.00	1,300,000,000.00
108	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	7,308,000.00
109	Үндсэн үйл ажиллагааны орлого		2,160,000.00
110	Туслах үйл ажиллагааны орлого		5,148,000.00
115	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-
120	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	18,000.00
121	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	2,380,978.00
122	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
123	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
124	ОНӨААТҮГ	1	1
126	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44	44
127	Удирдах ажилтан	1	1
128	Гүйцэтгэх ажилтан	6	6
129	Үйлчлэх ажилтан	37	37

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 329,435.8 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Залруулсан алдаа:

- Айл өрх, ААН-ийн хогны төлбөрийг Хэрлэн сумын төсөвт төвлөрүүлэхдээ тооцооны дансаар дамжуулалгүй орлого дансыг 327,559.1 мянган төгрөгөөр бууруулж бичсэн нь санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Ажлаас халагдсан хүний нормын хувцасны үнийг төлүүлэхдээ зардлын дансыг 1,876.7 мянган төгрөгөөр бууруулж бичсэн нь санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 12,365.9 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 2 албан шаардлага, 12,365.9 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Албан шаардлага

1. Хэрлэн тохижилт ОНӨААТҮГ нь байгууллагын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тус байгууллага нь Хэрлэн сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу байгууллагын гэрээний биелэлтийг дүгнүүлээгүй байна. Энэ нь "Хэрлэн сумын даргаас Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын захиралтай байгуулах гэрээ"-ний 4.2.1-д "Захирлын гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр Засаг дарга дүгнэнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: "Хэрлэн тохижилт" ОНӨААТҮГ нь байгууллагын автомашин, тээврийн хэрэгсэлд сэлбэг авахдаа авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэргийг бүрэн хөтөлж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэргийг бүрэн хөтөлх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
тооцооны дансаар дамжуулалгүй орлого бууруулж бичсэн	1	327,559.1	-	-	1	327,559.1	1	327,559.1	-	-	-	-

Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

зардлын дансыг бууруулж бичсэн	1	1,876.7			1	1,876.7	1	1,876.7				
Дүн	2	329,435.8	-	-	2	329,435.8	2	329,435.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт ны тоо	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллаагүй	1	-			1	-						
Хэрлэн сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу байгууллагын гэрээний биелэлтийг дүгнүүлээгүй	1	-			1	-						
байгууллагын автомашин, тээврийн хэрэгсэлд сэлбэг авахдаа авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэргийг бүрэн хөтлөөгүй	1	12,365.9					1	12,365.9				
Дүн	3	12,365.9	-	-	2	-	1	12,365.9	-	-	-	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 01/193 ДАА-2025/004/НА-СТА-0004Г-той бэлсэн хот
А1170308

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Хэрлэн тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулж батлуулан, мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Хэрлэн тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын захирал М.Алтанхуяг, нягтлан бодогч Ө.Пүрэвсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *Шууг* И.СЭМЖИДМАА
АУДИТОР *Тнс* Б.ОДХҮҮ



2125040565



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 02/ ДОА-2025/004/НМ-СТН-0484Г Чойбалсан хот
1194 А 1170308.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэрлэн сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлээгүй байна.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.5 дахь заалт “Төлөвлөгөөний биелэлтийн жилийн эцсийн тайланг дараах хугацаанд харьяалах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ”, 4.5.1 дэх хэсгийн “сум, дүүрэг, аймаг, нийслэл дэх агентлаг, орон нутгийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын төсвийн шууд захирагч 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллагад хүргүүлэн тайлагнах, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2125040562

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Хэрлэн тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын захирал М.Алтанхуяг, нягтлан бодогч Ө.Пүрэвсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН МЕНЕЖЕР *И.СЭМЖИДМАА*
АУДИТОР *Б.ОДХҮҮ*

